



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦӨГТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 17-өдөр

Дугаар 8/05

Амардалай

Тусгай горимд шилжин ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Улсын Онцгой Комиссын даргын 2020 оны 02-р сарын 13 ны өдрийн 04 дүгээр тушаал, Засгийн газрын 62 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 28 ны өдрийн 01 тоот албан даалгаврыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг: Шинэ коронавирусын халдварт болон томуу, томуу тест өвчний үед болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан Засаг даргын Тамгын газрын 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдын 2020 оны 02-р сарын 17 ны өдрөөс 03-р сарын 02 ны өдөр хүртэл хугацаанд албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажлын цагийн хуваарийг 09.00-12.00, 14.00-17.00 цагийн хооронд мөрдөн богиносгосон цагаар ажиллуулсугай.

Хоёр: Засаг даргын Тамгын газрын 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдын судалгааг хавсралтаар баталсугай.

Гурав: Хавсралтад нэр дурьдсан албан хаагчдын цалинг бүтнээр тооцож олгохыг нягтлан бодогч /Д.Долгорсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.НАРАНТУНГАЛАГ

4880600019